



МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/266

Улаанбаатар хот

Дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Их Хурлын 2014 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан "Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого"-ын 2.1.7 дахь зорилт, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.19 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 243 дугаар тогтоолоор батлагдсан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тав дахь хөтөлбөр"-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. "Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөр"-ийг геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжүүлж, ажлын байрны эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо /Г.Нандинжаргал/, Ашигт малтмал газрын тосны газар /Х.Хэрлэн/-т тус тус үүрэг болгосугай.


3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо /Г.Нандинжаргал/-д, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Одхүү/-д тус тус даалгасугай.

САЙД



Д.СУМЪЯАБАЗАР

Уул уурхайн, хүнд үйлдвэрийн сайдын
2018 оны А/206 дугаар тушаалын хавсралт



**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН
ДЭД ХӨТӨЛБӨР (2019-2020)**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Өнөөгийн байдал

Уул уурхайн үйлдвэрлэл эрчимжиж, Монгол Улсын нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл жил ирэх тусам нэмэгдэн энэ салбарт үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, ажиллагсдын тоо өссөөр байна. 2017 оны байдлаар уул уурхайн олборлох салбарт нийт 700 гаруй аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж, 23 000 гаруй хүн шууд хөдөлмөр эрхэлж байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт бүртгэгдсэнээр 2016 онд Монгол Улсын хэмжээнд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын нийт 332 тохиолдол бүртгэгдсэнээс уул уурхайн олборлох салбарт 18% нь буюу 61 тохиолдол бүртгэгдсэн байна. 2017 онд мөн 332 тохиолдол бүртгэгдэн үүнээс 55 нь уул уурхайн салбарт тохиолдсон бол 2018 онд нийт 265 тохиолдол бүртгэгдэж, нийт ослын тоо өмнөх оноос буурсан хэдий ч үүнээс 68 нь уул уурхайн салбарт гарч 11 хүн нас барж, 30 гаруй хүнд хэлбэрийн осол бүртгэгджээ. Дээрх тоо баримтаас харахад уул уурхайн салбарт үйлдвэрлэлийн осол хамгийн олон тохиолддог төдийгүй тус салбарын хэмжээнд хөдөлмөрийн хүнд, хортой ажлын байр олон байдаг нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)-н хувьд харьцангуй эрсдэл өндөртэй салбарт тооцогдох хүчин зүйл болж байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн салбарын зарим аж ахуйн нэгж, байгууллагууд тэр дундаа Оюу толгой ХХК, Эрдэнэт үйлдвэр ХХК зэрэг томоохон компаниуд ХАБЭА-н хууль, тогтоомж, дүрэм, журмыг сайн хэрэгжүүлж, дотооддоо хяналтын тогтолцоог бүрдүүлэн олон зуун ажилчдынхаа эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Гэсэн хэдий ч дийлэнх аж ахуйн нэгж, байгууллагуудад хууль, тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, хяналтын тогтолцоо сул, мэдлэг, мэдээлэл дутуу байсаар байгаа нь үйлдвэрлэлийн осол гарах шалтгаан нөхцөлийг бүрдүүлсээр байна. Ялангуяа бичил уурхай эрхлэгчид болон хууль бусаар ашигт малтмал олборлогчдын дунд аюулгүй ажиллагааны дүрэм журам ноцтой зөрчигдөх, амь насаа алдах, хүнд гэмтэл авах тохиолдол нилээд их байна.

Уул уурхайн үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд аюулгүй ажиллагааг хангах, холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг биелүүлэх талаар хангалтгүй байгааг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас захиалсан зөвлөх үйлчилгээний хүрээнд "Эс Эф Си Эс" ХХК-ийн хийсэн судалгаа харуулж байна. Уг судалгааг геологи, уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй 60 гаруй томоохон аж ахуйн нэгж, байгууллагын удирдах албан

тушаалтан болон ХАБЭА-н ажилтнуудын дунд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15 зүйл, 68 заалт бүхий асуумжаар санал асуулга авч явуулсан байна.

Уг судалгаанд сонгон авсан хуулийн заалтуудаас нь уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын дийлэнх аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хамаарах ба судалгааны үр дүнгээс харахад хуулийн хэрэгжилт хангалттай биш байгаа нь харагдаж байна.

Санал асуулгын дийлэнх асуултад нийт оролцогсод хангалтгүй гэсэн үнэлгээг өгч, цөөн хэдэн заалтын хувьд хэрэгжилт боломжийн буюу нийт оролцогсдын 60-аас дээш хувь нь сайн гэсэн үнэлгээг өгсөн байна.

Иймд ХАБЭА-н эрх зүйн орчныг илүү боловсронгуй болгож, хууль тогтоомжийг сурталчлах, ажилтан, ажил олгогчдын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төр засгаас анхаарч ажиллах зайлшгүй шаардлага тулгарч байна.

1.2. Эрх зүйн үндэслэл

Монгол Улс 1996 оноос “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж, 1997 онд Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын 155 дугаар конвенцид нэгдэн, 2008 онд ХАБЭА-н бие даасан хуультай болсноор эрх зүйн орчин бүрдсэн байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 2015 оны нэмэлт өөрчлөлтөөр тус хуулийн хэрэгжилтийг хангахад салбарын яам, бүх шатны Засаг дарга нарын оролцоог нэмэгдүүлэх талаар болон аж ахуй нэгж байгууллага, ажилтны үүрэг, хариуцлагын талаар тодорхой заасан байдаг. Мөн 2012 онд “Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо. Шаардлага олон улсын OHSAS 18001” стандартыг үндэсний стандарт болгон батлуулсанаар олон улсын жишигт нийцсэн эрхзүйн хүрээний томоохон дэвшил гарсан гэж үздэг.

“Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 2.1.7-д эрдэс баялгийн салбар дахь ХАБЭА-н хууль тогтоомжийг боловсронгуй болгох, стандартыг олон улсын түвшинд хүргэж, хэрэгжилтийг хангах; Ашигт малтмалын тухай хуулийн 44.1-д Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь зохих хууль журмын дагуу уурхай, ажиллагсдын хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн нөхцөл болон тухайн сум дүүргийн иргэдийн аюулгүй байдлыг харгах талаар тодорхой үйл ажиллагаа явуулна.

Газрын хэвлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2.2-д газрын хэвлийг ашиглахдаа ажиллагчдын болон хүн амын аюулгүй байдлыг хангах; зэргээр салбарын хуулиудад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар онцгойлон заасан байдаг.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлаар 2015 оны 7 дугаар сарын 3-ны өдөр баталсан “Конвенцид нэгдэн орох тухай” Монгол Улсын хуулийн дагуу “Уурхай дахь аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 176 дугаар конвенцид нэгдэн орсон. Конвенцид нэгдэн орсоноороо Монгол Улс Олон Улсын өмнө үүрэг хүлээж, Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын дүрмийн дагуу тухайн конвенцийг биелүүлэх талаар тодорхой алхамуудыг хийж байх ба тайланг хугацаанд нь хүргүүлэх үүрэг хүлээсэн.

“Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.19-д Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, эрх зүйн орчин, санхүүжилтийн механизмыг оновчтой болгоно гэж заасан ба “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний 5 дахь хөтөлбөр”-ийг хэрэгжилтийг салбартаа зохион байгуулах, аюулгүй ажиллагааны дүрэм, журам, стандартыг шинэчлэн боловсруулж, олон улсын жишигт нийцүүлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох яамдууд дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг даалгасан.

Иймд Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хорооноос Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөрийг боловсруулсан болно.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/59 дугаар тушаалаар байгуулагдсан Уул уурхай, хүнд үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо нь салбарт зонхилж буй үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг оновчтой, хүртээмжтэй төлөвлөн зохион байгуулах чиг үүрэгтэй ажиллаж байна.

ХОЁР. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ЗАРЧИМ

2.1. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, ажилтан ажиллагсдыг хамарна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын ХАБЭА-н тогтолцоонд оролцогч талууд:

- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам;
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороо;
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо;
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар;
- Ашигт малтмал, газрын тосны газар;
- Стандарт, хэмжилзүйн газар;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв;
- Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн зөвлөл, асуудал хариуцсан ажилтан;
- Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо;

- Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны дэргэдэх Эрчим хүч, геологи, уул уурхайн үйлдвэрчний эвлэлийн холбоо;
- Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй нийт аж ахуйн нэгж, байгууллагууд, ажилтан ажиллагсад;
- Сургалт, зөвлөх үйлчилгээ, баталгаажуулалтын байгууллага;
- Мэргэжлийн төрийн бус байгууллага;
- Эрдэмтэн, судлаачид.

2.2. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Манлайлал, оролцоонд тулгуурлаж, нэгдмэл байх;
- Судалгаа, шинжилгээнд суурилан эрсдэл өндөртэй үйл ажиллагаанд түлхүү анхаарах;
- Нийгмийн түншлэлийг эрхэмлэх;
- Ил тод, нээлттэй байх.

ГУРАВ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

3.1. Хөтөлбөрийн зорилго.

Монгол Улсын геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт ХАБЭА-н эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдлыг бууруулах, урьдчилан сэргийлж, салбарт ажиллагсдын амь нас, эрүүл мэндийг сахин хамгаалахад оршино.

3.2. Энэхүү зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжүүлнэ.

- 3.2.1. Салбарын түвшинд хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлж, дүгнэх, сайжруулах;
- 3.2.2. Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийг тогтолцооны стандартыг нэвтрүүлэх;
- 3.2.3. “Нэн түрүүнд ХАБ” соёлыг түгээн дэлгэрүүлэх;
- 3.2.4. ХАБЭА-н хяналтын тогтолцооны чадамжийг дээшлүүлэх;
- 3.2.5. Үр дүнд суурилсан сургалтын тогтолцоог бүрдүүлэх;
- 3.2.6. Салбарын ХАБЭА-н мэдээллийн сан байгуулах.

ДӨРӨВ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.1. Салбарын түвшинд хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлж, дүгнэх, сайжруулах хүрээнд.

- 4.1.1. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх арга зүйг салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудад эзэмшүүлэх;

- 4.1.2. Хэрэгжилтийн үнэлгээг хийх, үр дүнг нэгтгэх, статистик мэдээлэл боловсруулах, олон нийтэд мэдээллэх,
- 4.1.3. ХАБЭА-н тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгоход талуудын оролцоог хангаж, саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлэх;
- 4.2. Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийг тогтолцооны стандартыг нэвтрүүлэх хүрээнд.
- 4.2.1. Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийг тогтолцооны стандартыг сурталчлах, сайн туршлагыг дэлгэрүүлэх;
- 4.2.2. Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийг тогтолцооны стандартыг нэвтрүүлэхэд зөвлөн туслах, мэргэшил аргазүйн удирдамжаар хангах.
- 4.3. “Нэн түрүүнд ХАБ” соёлыг түгээн дэлгэрүүлэх хүрээнд.
- 4.3.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27.3.2 аж ахуйн нэгж, байгууллага нь “...хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжилт, үр дүнд хяналт тавих” гэсэн заалтын хэрэгжилтийг хангах талаар мэргэжлийн хяналтын байгууллага болон сургалт, зөвлөх үйлчилгээ, аудит, баталгаажуулалтын байгууллагуудтай хамтран ажиллах;
- 4.3.2. Vision zero олон улсын хөдөлгөөнд Монгол Улс нэгдэн орох уриалгыг дэвшүүлэх;
- 4.3.3. Vision zero хөдөлгөөнд салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудыг нэгдэх ажлыг зохион байгуулах;
- 4.3.4. Vision zero үзэл баримтлалын 7 алтан дүрмийн дагуу сургалт, сурталчилгаа явуулах талаар сургалтын байгууллагуудтай хамтарч ажиллах;
- 4.3.5. Олон улсын ISO 45001, OHSAS 18001 стандарт, Vision zero үзэл баримтлалын 7 алтан дүрмийг хэрэгжүүлсэн байгууллагуудын туршлагыг түгээн дэлгэрүүлэх;
- 4.3.6 Жил бүр зохион байгуулагддаг “Нэн түрүүнд ХАБ” бага хуралд геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбар манлайлж, оролцох.
- 4.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын тогтолцооны чадамжийг дээшлүүлэх хүрээнд.
- 4.4.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны гишүүдийг чадавхижуулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх;
- 4.4.2. УУХҮЯ, АМГТГ, аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдах бүрэлдэхүүн, зөвлөлийн гишүүдэд сургалт, семинар зохион байгуулж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль тогтоомжийн талаар мэдлэг олгох, хэрэгжүүлэх асуудлаарх ойлголтыг нэгтгэх, чадамжийг дээшлүүлэх.
- 4.5. Үр дүнд суурилсан сургалтын тогтолцоог бүрдүүлэх хүрээнд.
- 4.5.1. ААН, байгууллагын дээд удирдлага, ХАБЭА-н ажилтнуудаас ХАБЭА-н мэргэжилтэн бэлтгэх болон ХАБЭА-н сургалтын талаар хэлэлцүүлэг

зохион байгуулж, ХАБЭА-н сургалтын хэрэгцээг тодорхойлох ажлыг зохион байгуулах;

4.5.2. Үр дүнд суурилсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх талаар Монголын мэргэшсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтнүүдийн холбоо, ХАБЭМ-ийн төвтэй хамтран ажиллах;

4.5.3. Дээрх байгууллагуудтай хамтарч сургагч багш нарыг сургах, мэргэшүүлэх, үнэлэх, баталгаажуулах тогтолцоог бүрдүүлэх ажлыг зохион байгуулах.

4.6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдээллийн сан бүрдүүлэх хүрээнд.

4.6.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдээлэл, судалгаа, шинжилгээ, сургалт, сурталчилгааны бүтцийг талуудын оролцоотойгоор бий болгох;

4.6.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх салбарын мэдээллийн сантай болох;

4.6.2 Мэдээллийн санг нээлттэй, ил тод болгож холбогдох үйл ажиллагаанд ашиглах.

ТАВ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

5.1. Дэд хөтөлбөрийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний хооронд хэрэгжүүлнэ.

5.2. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг салбарын хэмжээнд удирдан зохион байгуулах үүргийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо Ашигт малтмал, газрын тосны газартай хамтран хэрэгжүүлнэ.

5.3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага энэ хөтөлбөрийн хүрээнд өөрт хамаарах зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг хүлээнэ.

ЗУРГАА. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

6.1. Дэд хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ. Үүнд:

- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас энэ зориулалтаар гаргах хөрөнгө;
- Хамтын ажиллагаатай гадаад орон, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр, буцалтгүй тусламж;
- Аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгө;

ДОЛОО. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ, ДҮН ШИНЖИЛГЭЭ

- 7.1. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд салбарын хэмжээнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороотой хамтран гүйцэтгэнэ.
- 7.2. Дэд хөтөлбөрийн явцын дунд хугацааны үнэлгээг хөтөлбөрийг хэрэгжиж эхэлснээс хойш 2 жилийн дараа, эцсийн үнэлгээг дэд хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараа хийнэ.
- 7.3. Дэд хөтөлбөрийн хяналт, үнэлгээ, дүн шинжилгээнд ажилтны болон ажил олгогч төлөөллийн байгууллага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулна.
- 7.4. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, түүний үр дүнгийн талаарх мэдээ, тайланг яамны цахим хуудас (www.mmhi.gov.mn)-аар дамжуулан олон нийтэд ил тод нээлттэй мэдээлнэ.
- 7.5. Дэд хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт, үнэлгээ, дүн шинжилгээнд дараах шалгуур үзүүлэлтийг ашиглана.
- 7.5.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын тоо;
 - 7.5.2. Тухайн жил бүртгэгдсэн мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн тохиолдлын тоо;
 - 7.5.3. Тухайн жилд гарсан үйлдвэрлэлийн ослын тоо;
 - 7.5.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтанд хамрагдсан ажилтны тоо;
 - 7.5.5. Уурхай, үйлдвэр, аж ахуйн нэгжийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөлийн тоо;
 - 7.5.6. Аж ахуйн нэгж байгууллагын үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх комиссын тоо;
 - 7.5.7. Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэг зохион байгуулсан аж ахуйн нэгж, байгууллага, хамрагдсан ажилчдын тоо;
 - 7.5.8. Шинээр байгуулагдсан болон шинэ тоног төхөөрөмжөөр хангагдсан хөдөлмөрийн нөхцөл, эрүүл ахуйн лабораторийн тоо;
 - 7.5.9. Хийгдсэн хяналт, шалгалт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр нөлөөтэй байдал.